

тодорхойлсон албан ёсны мэргэжлийн байгууллагын дүгнэлт одоо болтол байхгүй байгаа нь бидэнд ихээхэн хүндрэл учруулж байна.

Цагдаагийн албанд ашигладаг хамгаалах тусгай хэрэгслүүдийн чанар, стандартыг дотооддоо тогтоож бий болгон мөрдөж ажилласнаар цаашид алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй албан үүргээ итгэлтэй гүйцэтгэх боломж бүрдэх юм.

Энд сонирхуулахад 1914 оны 07 дугаар сарын 15(28)-нд Сербийн Сараево хотод Австри-Унгарын эзэнт гүрний хунтайж Франц Фердинанд руу халдаж, амийг нь хөнөөсөн нь хүн төрөлхтөнд гамшиг (5.6 сая хүн амь үрэгдсэн) учруулсан Дэлхийн I дайны шалтаг болсон.

Хамгийн гол нь хунтайжийн өмссөн хамгаалах хантааз нь түүний амийг хамгаалж чадаагүй гэж мэргэжилтнүүд дүгнэдэг аж.

Эцэст нь цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах, эрсдлийг бууруулахад хамгаалах тусгай хэрэгслийн үүрэг

оролцоо их чухал байр суурь эзлэх болно гэж харж болохоор байна. Энэхүү асуудлын хүрээнд дараах цөөн хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчдын албанд ашиглаж байгаа хамгаалах тусгай хэрэгслийн чанарыг мэргэжлийн стандарт хэмжил зүйн төв лабораториар оруулж баталгаажуулах

2. Цагдаагийн төв байгууллага албандаа ашиглах хамгаалах тусгай хэрэгслийг олон орны цагдаагийн албанд ашиглаж байгаа тусгай хэрэгслүүдтэй харьцуулан судалж, судалгаа хийсний эцэст авч ашиглаж байх

3. Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдад хамгаалах тусгай хэрэгслийг хүрэлцэхүйц хэмжээгээр авч нийт алба хаагчдыг бүрэн хангах

4. Хамгаалах тусгай хэрэгслийг шалгахдаа ХСИС-ийн ШУТГ болон Шинжлэх ухааны академийн холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран ажиллах

Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ БА ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА LEGAL REFORM AND POLICE



Б.Баянмөнх. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

Bayanmunkh.B. Police captain, Senior Lecturer of the Police law faculty, Law Enforcement University

Abstract: There are many difficulties in and reforms. In this article the author has tried to show that all reforms should be based on results of research and advisement on reforms should be done by media widely. Psychological acceptance in society. Is very important moment in the reform. There are some interactive points concerning social psychology.

шилжээд хорь гаран жил болсон мөртлөө цэрэг, цагдаа, шүүх гээд аюулгүй байдлыг сахин хамгаалах байгууллагуудынхаа тогтолцоог өнөөгийн нийгэмд нийцүүлэн шинэчлэх талаар далайцтай өөрчлөлт хийж амжаагүй удсан билээ.

Холбогдох хуулиудыг ганц нэгээр нь өөрчилж,

зарим талаар эрхзүйн орчин нь шинэчлэгдэж ирсэн боловч яг бүтэц, тогтолцооныхоо хувьд өмнөх нийгмийн хэв шинжийг хадгалсаар ирсэн. Шинэчлэлийн үзэл санаа туссан хэсэг бусад оролдлого хийж ирсэн боловч цогцоор нь өөрчилж чадаагүй

билээ.¹⁴⁷

Тухайлбал 1993 онд баталсан Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулинд 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000, 2002, 2003, 2007, 2009 онуудад нийт 16 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдлаар нь харж болох юм.

Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан “Шинэчлэл-Сэтгэл гарган хийх ажил” сэдэвт төрийн албан хаагчдын анхдугаар уулзалт дээр “Шинэчлэлийн Засгийн газраас хийж байгаа ажил, зорьж байгаа төлөвлөгөөг төрийн албаны бүх шатандаа ойлгож хүчээ нэгтгэх нь чухал”¹⁴⁸ гэсэн байна.

Төрийн албан хаагчид анх удаагаа өргөн бүрэлдэхүүнээр цугласан энэ уулзалтын үеэр Засгийн газрын бүх сайд хариуцсан салбартаа хийж буй ажил, шинэчлэлийг танилцуулсаны дотор Хууль зүйн сайд Х.Тэмүүжин “Монгол Улсад хууль нь хууль шиг бүгдэд адил тэгш үйлчилдэг, хууль сахиулагчид нь хуулиндаа захирагддаг байхын тулд Хууль зүйн яам эрх зүйн шинэчлэлийг эхлүүлсэн” гэж онцлон хэлсэн байдаг.

Тэрээр телевизийн нэгэн ярилцлаган дээр “Яг энэ шинэтгэл дээр зохиогч гэж байхгүй. Энэ бол шилжилт хийгдэж байгаа 23 жилийн турш яригдаж байсан. Заримдаа ихэнх тохиолдолд хэн нь ч зүрхэлж барьж аваагүй байсан байх. Мөн улс төрийн таатай дэмжих боломжтой орчин бүрдээгүй байсан байж магадгүй. Нөгөөтэйгүүр олон нийт хэрэгцээ гэж мэдэрч улс төрдөөс шахаж, хүчтэй илэрхийлж амжаагүй байж магадгүй”¹⁴⁹ гэж хэлсэн байдаг.

Өнөөдөр Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэтгэлийн бодлого 5 үндсэн чиглэлээр явж байна. Үүнд:

- Эрх зүйн шинэтгэлийн бодлогыг боловсруулах стратегийг боловсруулах
- Үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох
- Шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын, хүний эрхийг хангах чиглэлээр болон эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах
- Хуулийн төслийн судалгаа хийх
- Боловсруулж буй хуулийн төслийн үр нөлөөг

¹⁴⁷ 2012 оны 5 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдлын бодлогын зөвлөх М.Батчимэгтэй сэтгүүлчтэй хийсэн ярилцлагаас хэсэгчилэн авав. <http://politics.news.mn/>

¹⁴⁸ 2013 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Буянт-Ухаа спорт цогцолборт яам, агентлаг болон нийслэлийн захиргааны бүх байгууллагын 7000 гаруй албан хаагч, төлөөлөгч нар оролцсон “Шинэчлэл-Сэтгэл гарган хийх ажил” сэдэвт төрийн албан хаагчдын анхдугаар уулзалтан дээр хэлсэн үг. <http://moj.gov.mn/>

¹⁴⁹ 2014 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн “25-р суваг” телевизийн “Дуусдаггүй яриа” нэвтрүүлгээр УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжингийн өгсөн ярилцлагаас хэсэгчилэн авав. <http://parliament.news.mn/content/171252.shtml>

тандан судлах,¹⁵⁰

Аливаа шинэчлэлийг хийхэд янз бүрийн бэрхшээл тулгарна. Гэхдээ шинэчлэлийг хийхийн тулд энэ чиглэлээр хийгдсэн олон судалгааны ажлын дүнг харж байж шинэчлэлийг хийдэг тул үүнийг тухайн салбарын ажилтан, алба хаагч нарт тайлбарлан таниулан ойлгуулах, сурталчилах, үйл ажиллагаандаа ашиглах аргачилсан зааварчилгаа, хуулийн зүйл заалтыг хэрхэн ашиглах талаархи сургалтын ажлыг маш их далайцтай байдлаар зохион байгуулж хийх хэрэгтэй шаардлагатай болно.

Хууль зүйн салбарын шинэчлэл бол Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх чухал үйл хэрэг юм. Хууль зүйн салбарын шинэчлэл нь цогц шинэчлэл байх ёстой. Эрх зүйн орчинг бүхлээр нь шинэчлэхээс эхлэн институтийн хувьд өөрчлөх, бүтэц зохион байгуулалт, санхүү, дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчилж байж шинэчлэлийн бодлого бүрэн утгаараа хэрэгжинэ. Энэ салбарт шинэчлэлийн их хүлээлт иргэд болон салбарынханд байгаа тул хугацаа алдахгүй хэрэгжүүлэх ёстой.¹⁵¹

Шинэчлэл нь асуудал тулгарахтай зэрэгцэн бий болдог зүйл бөгөөд уг асуудлыг шийдвэрлэх явцад улам лавширч байдаг. Улс орны хөгжлийн явцад үүсдэг зөрчил, үл ойлголцлын асуудлыг шийдвэрлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хэрэгжүүлж иргэдийн амьдралыг шинэчлэхийн тулд олон талын шинэчлэлийн үндсийг бий болгох шаардлагатай байдаг.

Өнөөдөр хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлого эрчимтэй өрнөж, энэ чиглэлийн маш олон хуулийн төсөл, хөтөлбөрүүд боловсруулагдаж, эхний хэсэг нь батлагдаж, зарим нь төслийн шатандаа явж байна. Үүнийг судлаачийн хувьд зүйтэй, цагаа олсон асуудал гэж үздэг.

Бид шинэчлэлийг хийхдээ гадны орнуудын тухайн салбартаа хийгдсэн, түүнийг практикаар туршигдаж тодорхой үр дүнд хүрсэн технологийн ололтыг өөрийн хөрсөнд сайтар нутагшуулж хийх ёстой. Гэхдээ монгол соёл уламжлал, сэтгэлгээ, ахуйд нийцүүлсэн байх ёстойг анхаарах нь зүйтэй болов уу.

Ер нь уул уурхай, хууль зүй гээд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын хөгжлийн түлхүүр нь эцэстээ хүний хөгжил байдаг. Гадны туршлагыг ашиглахдаа үндэсний шинжийг хадгалахын зэрэгцээ даяаршиж буй дэлхийн чиг хандлагаас гажих ёсгүйг сайтар ухамсарласан байх ёстой.

Анзаараад байхад аливаа шинэчлэлийг хийхэд хүлээж авах нийгмийн сэтгэл зүй их чухал байдаг нь хууль зүйн салбарт хийж байгаа шинэчлэлийн

¹⁵⁰ moj.gov.mn

¹⁵¹ Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэгийн “Хууль зүйн салбарын шинэчлэл бол Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх чухал үйл хэрэг” сэдвээр сэтгүүлчтэй хийсэн ярилцлагын хэсгээс хэсэгчилэн авав. http://www.moj.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=261:turiin-nariin-yariltslaga&catid=66:talk&Itemid=155

үйл явцаас харагдаж байна. Энэ нь тухайн салбарт нь ажиллаж байгаа хүмүүсийн сэтгэл зүйн бэлтгэл хангагдах маш чухал асуудал байдаг.

Үүнийг цагдаагийн зарим алба хаагчидтай уулзаж, санал бодлыг нь сонсоод ярилцаж байхад цагдаад тийм хөрс нь бий болчихсон байна. Тухайн цагдаагийн албан хаагчтай холбоотой гэхээс илүүтэй төрийн бодлого, зохицуулж байгаа хууль эрх зүй, цагдаагийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлууд голдуу байгаа нь анзаарагдсан. Үүнийг цагдаа дотроосоо маш сайн мэдэрч, ойлгож байгаа нь шинэчлэл үр дүнтэй болоход чухал нөлөө үзүүлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хуулиуд өөрчлөлт дотроосоо, дотор нь ажиллаж байгаа хүмүүстээ тулгуурлан хийгдэх ёстой гэдэг үзэл санааг баримталсан гэдэг нь харагдаж байна.

Төрийн алба, тэр дундаа цагдаагийн алба гэдэг иргэдийн өмнөөс нийгмийн сөрөг үзэгдэлтэй тэмцдэг, хатуу ширүүнийг үүрч, хүнд хэцүүтэй тулгардаг алба учраас тэдний нийгмийн баталгаа нь төрийн бусад албан хаагчдаас арай илүү өндөр түвшинд байх ёстой гэж үзэж судлаачийн хувьд үздэг бөгөөд Цагдаагийн албаны болон Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар илүүтэйгээр тодотгож өгч байгаа нь алба хаагчдад сэтгэл ханамжийг бий болгож байна.

Шинэчлэлийн бодлогын үндсийн үндэс нь судалгаа байдаг..

Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхлээд 3 сар болж байна. Өнөөдөр хуулийг зөв ойлгож хэрэглэх асуудал бол том асуудал болоод байна. Өөрөөр хэлбэл хууль тогтоох төрийн дээд байгууллага маань ард иргэдээ Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх, айх аюулгүй амар тайван орчинд ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомж гаргадаг.

Ер нь хууль сахиулах үйл ажиллагааны эцсийн үр дүн нь иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангахуйц нөхцөл боломжийг бүрдүүлэх явдал юм.

Өмнөх Цагдаагийн байгууллагын тухай хууль ихэвчлэн ерөнхий асуудлыг зохицуулж, зарим нэг шаардлагатай асуудлыг орхигдуулсан байсан учраас өнөөдрийн тулгамдаж буй асуудал иж бүрэн шийдэгдэж, эрх зүйн зохицуулалт болж чадаагүйгээс шинэчлэлт хийж эхэлсэн гэж судлаачийн хувьд үздэг.

Цагдаагийн албаны тухай хууль батлагдаж, 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд хуулийг дагаж мөрдөн хэрэглэж байгаа цагдаагийн алба хаагчид маань уг хуулийнхаа хамгийн гол утга учрыг төдийлөн дутуу ойлгоод байх шиг байна. Энэ нь асар их хор уршигтай, үр дагавартай байна.

Энэхүү хуулиар цагдаагийн байгууллага нийтийн хэв журам сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад ямар эрх, үүрэгтэйгээр оролцохыг тодорхой зааж өгсний зэрэгцээ үүнд иргэд хүртэл өөрөө оролцож байж иргэд, олон нийтийн аюулгүй байдал хэрэгжихээр эрх зүйн зохицуулалт орсон

байна.

Түүнээс гадна Цагдаагийн байгууллага маань хууль сахиулах үйл ажиллагааны чиглэлээр өөрийнхөө дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр шинэ бүтэц, зохион байгуулалтаар Дотоод хяналт, аюулгүй байдлын албыг байгуулж үйл ажиллагааных нь чиглэлийг тодорхойлж, ажлаа эрчимжүүлж байгаа нь алба хаагчид хүний эрхийг дээдэлсэн хууль сахиулах ажлаа хууль тогтоомж, стандартаар явуулах, түүнд тавих хяналтыг цогц байдлаар явуулахаар болж байгаагаас харж болох юм.

Харин төр иргэнд суурилсан хяналтыг хэрэгжүүлнэ. Тэгснээр иргэнд үйлчлэх хууль сахиулах салбарын үйл ажиллагаа жинхэнэ утгаараа хүний эрхийг дээдэлсэн хэлбэрээр хэрэгжих боломж бүрдэх бололцоотой болно.

Нөгөө талаараа энэ хууль батлагдан гарснаар цагдаагийн байгууллагын нуруун дээр байсан олон ачаануудынхаа заримаас салж, чиг үүргийнх нь дагуу бусад төрийн байгууллагад өгч, үндсэн чиглэл болох урьдчилан сэргийлэх тал руу ажиллах нөхцөл боломж бүрдэж эхэлж байна.

Цагдаагийн албаны тухай хуулиар алба хаагч ямар эрх эдэлж, үүрэг хүлээх талаар нарийн тусгасан. Гэтэл амьдрал дээр бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаа нь хэрэгжүүлэх механизмаа ойлгохгүй байгаатай салшгүй холбоотой юм.

Бидэнд тулгарч байгаа бас нэг том асуудал бол хуучин тогтолцоогоор явж ирсэн алба хаагчдын сэтгэлгээг өөрчлөх явдал юм. Өнөөдөр цагдаагийн байгууллага хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн орчинг тодорхой үе шаттайгаар шинэчлээд явж байна. Бас алба хаагчдынхаа үүрэг гүйцэтгэхэд шаардлага хангахуйц дүрэмт хувцасны загварыг бий болгоод удахгүй алба хаагчдаа хангах гэж байна.

Тэгвэл өнөөдөр цагдаагийн алба хаагчдын сэтгэлгээг яаж хуучин тогтолцооноос нь өөрчилж, эрх зүйн шинэтгэлийн бодлоготой уялдуулан хүний эрхийг дээдэлсэн хууль сахиулах үйл ажиллагаа явуулах сэтгэхүйг төлөвшүүлэх, үүнийг хэрхэн ямар арга замаар хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болоод байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

Цагдаагийн байгууллага дээр явуулж буй шинэтгэлийн бодлого цогц байдлаар явагдаж байж, үр дүнд хүрнэ гэдгийг алба хаагч бүр сайтар ухамсарлаж, хамгийн бага нэгжээс, өөрөөр хэлбэл алба хаагч өөрөөсөө шинэчлэлийг хэрэгжүүлбэл үр дүн нь хурдан гарах боломжтой болох юм.

Хамгийн гол нь бид хууль сахиулагчдынхаа сэтгэлгээг өөрчлөх, хүний эрхийг дээдэлсэн хууль сахиулах үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрхэн яаж хэрэгжүүлэх арга замыг маш богино хугацаанд олж, зааж сургах цаг тулгарч байна.

Хууль зүйн дэд сайд Э.Эрдэнэжамъян сэтгүүлчтэй хийсэн нэгэн ярилцлагандаа "Манай шинэчлэлийн гол бодлого бол хуулиар дээрлэхдэг байсан байгууллагыг хуулиа дээдэлдэг зарчимд

шилжүүлэх явдал юм”¹⁵² гэж хэлсэн байдаг.

Ер нь цагдаагийн алба өөрөө хуулийн хүрээнд хуулиа ягштал мөрдөөд ажиллана гэдэг бол бусдаас хараат бус байх баталгааг бий болгож байгаа явдал юм.

Өнөөдөр ямар ч иргэн айх аюулгүй амар тайван орчинд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ саадгүй эдлэх, ажил хөдөлмөр эрхэлж, түүнийхээ үр шимийг хүртэх боломжийг нь олгох, нөгөө талаараа иргэнээ сайхан амьдруулахын тулд төрийн байгууллага батлагдсан хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах ёстой байдаг.

Хууль сахиулагч цагдаагийн алба хаагч энэ мөн чанараа ойлгож байхад л ямар ч асуудал үүсэхгүй байх боломжтой болох юм. Гэтэл өнөөдөр болж л өгвөл хуулийн шийтгэлийн хэсгийг нь түрүүлж хэрэглэх гээд байдаг хандлага түгээмэл болсон байна.

Бид үүнийг өөрчлөх ёстой гэж үздэг. Товчхондоо, ямар ч хүний амьдралаас илүү, дээгүүр хөндөгдөх бичиг баримт, хууль байх ёсгүй.¹⁵³

Төрийн албан хаагч хуулийг дагаж мөрдүүлэхийн төлөө ажиллана, харин тэр хууль нь иргэний сайн сайхны тулд чиглэгдсэн байх ёстой. Өнөөдөр төрд ажиллаж байгаа хүн иргэнд хуулийг тайлбарлаж үйлчлэх ёстой болохоос заадаг, зааварладаг, зандардаг байх ёсгүй гэдгийг алба хаагч нарын сэтгэлгээнд нэн түрүүнд суулгаж өгөх ёстой болж байна.

Шинэ хуулиар цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан хийсэн зарим өөрчлөлт шинэчлэлтүүдийн заримаас дурдвал:

- Хүний наймаа, мөнгө угаах, терроризмтэй тэмцэх, үндэстэн дамнасан том хэргүүд, албан тушаалын гэмт хэргүүдтэй тэмцэх тусгайлсан мөрдөх албыг байгуулж, эдгээр чиг үүргийг цагдаагийн байгууллагаас шилжүүлэх зохицуулалт орж байгаа
- Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дэргэд иргэний зөвлөл байгуулахаар хуульд тусгасан явдал. Энэ нь нэг талаар цагдаа, иргэн хоёрыг холбох механизм бүрдэх, нөгөө талаар хууль сахиулах үйл ажиллагаа хуулийн хүрээнд явж байгаа эсэхэд тавих хяналтын механизмыг бий болгох нөхцлийг бүрдүүлсэн.
- Цагдаагийн байгууллагын тогтолцоог өөрчилж, шинээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг нэмж тусгасан
- Цагдаагийн алба хаагч ажил үүргээ гүйцэтгэж яваад бэртэж гэмтэж, амь насаараа хохирч

байгаа явдал гарсаар байна. Энэ тохиолдолд олгодог нөхөн олговор, тэтгэмжийн хэмжээ бага, бусад орнуудынхтай харьцуулахад хэтэрхий бага байсныг нэмэгдүүлсэн.

- Цагдаагийн хууль сахиулах ажил үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэдэг байсан тусгай хэрэгсэл чанаргүй, стандартгүй байсныг өөрчилж, чанарын стандарт, шаардлага хангасан тусгай хэрэгслээр хангах, хэрэглэх стандартыг бий болгох тусгайлсан төв байгуулсан.

Ерөнхийлөгч болон Хууль зүйн сайдын санаачилсан эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй ажлууд Монголын нийгэмд тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдэх зорилготой байдаг учир бэрхшээлтэй боловч даваад гарч, амжилттай хэрэгжинэ гэдэгт судлаачийн хувьд итгэлтэй байна.

Эцэст дүгнэж хэлэхэд шинэчлэлийн бодлогын агуулгын мөн чанарыг цагдаагийн байгууллага, алба хаагч бүр сайтар ухамсарлаж, удирдах албан тушаалтан, алба хаагч хэн ч бай бүгд өөрөөсөө шинэчлэлийг эхэлж хэрэгжүүлбэл үр дүн нь хурдан гарах бололцоотой гэдгийг нутаг дэвсгэр, нэгж хариуцсан байгууллагын дарга нар анхааралдаа авч, хийх ажлынхаа төлөвлөлтийг боловсруулахдаа энэ асуудлыг тусгайлан авч оруулах нь зүйтэй болов уу.

Нөгөө талаасаа бид цагдаагийн алба хаагчдынхаа хуучин тогтолцооны сэтгэлгээг өөрчилж, хүний эрхийг дээдэлсэн хууль сахиулах үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрхэн яаж хэрэгжүүлэх арга замыг эрэлжхийлж, эрх зүйн орчныг хурдан бий болгох шаардлагатай болсныг хэлэх нь зүйтэй юм.

Эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлж буй цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай байж болох дараах 2 саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Алба хаагчдын дунд эрх зүйн шинэчлэлийн агуулга, мөн чанарыг тайлбарлан ойлгуулах сургалтыг зохион байгуулж, хуучин дархлаажин тогтсон сэтгэлгээг өөрчлөх ажлыг удирдах бүрэлдэхүүнээс эхлээд нэгж хэсэг, алба хаагчдын дунд эрчимтэй, системтэйгээр зохион байгуулах

2. Цагдаагийн байгууллага дээр явагдаж байгаа шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэл чухал үүрэгтэй байх учир тэдний сэтгэл зүйн бэлтгэлийг бүрэн хангахуйц арга хэмжээ авах

¹⁵² Хууль зүйн дэд сайд Э.Эрдэнэжамъян орон нутагт ажиллаж ирсний дараа сэтгүүлчтэй салбарын шинэтгэл, өөрчлөлтийн талаар хийсэн ярилцлагаас хэсэгчлэн авав. <http://www.moj.gov.mn/>

¹⁵³ Хууль зүйн дэд сайд Э.Эрдэнэжамъян орон нутагт ажиллаж ирсний дараа сэтгүүлчтэй салбарын шинэтгэл, өөрчлөлтийн талаар хийсэн ярилцлагаас хэсэгчлэн авав. <http://www.moj.gov.mn/>